



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 0/200

Улаанбаатар хот

**Баянгол дүүргийн 100 дугаар
цэцэрлэгийн данс бүртгэлд эргэлтийн
бус хөрөнгө бүртгэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.7, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу нийт 600,000.0 /зургаан зуун мянган/ төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг хавсралтын дагуу данс бүртгэлдээ бүртгэн авахыг Баянгол дүүргийн 100 дугаар цэцэрлэг /Ц.Дэлгэрмаа/-т зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Баянгол дүүргийн 100 дугаар цэцэрлэг /Ц.Дэлгэрмаа/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс /М.Энхболд/-т тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
газрын даргын 2019 оны 07 сарын
08 өдрийн 01202 дугаар тушаалын хавсралт



Хандив тусламжийн хөрөнгө бүртгэлд авах жагсаалт

Байгууллагын нэр: Баянгол дүүргийн 100 дугаар цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт	Үйлдвэрлэсэн он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх анхны		Хандивлагч	
								Нэгжийн үнэ	Нийт үнэ	Нэр	Эх үүсвэр
1	Хүүхдийн хувцасны шүүгээ			2019	сайн	ш	1	250,000.0	250,000.0	Таван богд ХХК	Хандив
2	Сургалтын хэрэглэгдхүүний тавиур, хүүхдийн буйдан			2019	сайн	хос	1	350,000.0	350,000.0	Эцэг эх	Хандив
Нийт хөрөнгийн дүн									600,000.0		